

“STEM салбарт охидыг дэмжих”

Тэтгэлэгт Хөтөлбөр 2022-2023



Women Empowerment Mongolia (WE Mongolia) ТББ нь АНУ-д бүртгэлтэй ашгийн бус эмэгтэйчүүдийн байгууллага. Бидний эрхэм зорилго бол мэдээлэл, мэдлэг, менторт суурилсан нөлөөллийн хүрээг бэхжүүлэн, охид эмэгтэйчүүдэд STEM-ийн чиглэлээр суралцах боломжийг нээж, охидын манлайлалыг дэмжих замаар жендэрийн тэгш байдлыг хангахад хувь нэмрээ оруулах юм.

Тэтгэлэгийн Зорилго

- STEM (шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик)-ийн чиглэлээр суралцан, улмаар мэргэжлээрээ ажиллах чин хүсэлтэй, сурлага сайтай охидыг дэмжин, санхүүгийн болон техникийн тусламж үзүүлэх.
- STEM-ийн салбар дахь жендэрийн харьцааг тэнцүүлэх, эрх тэгш боломжийг хангах тухай Тогтвортой Хөгжлийн 5-р зорилгыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах.

Тэтгэлэгийн хүрээ

WE Mongolia ТББ-аас хэрэгжүүлж буй “STEM салбарт охидыг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн 5 эмэгтэй оюутныг сонгон шалгаруулж 2022-2023 оны хичээлийн жилд тус бүр 1,000,000 төгрөгийн сургалтын тэтгэлэг олгоно. Энэхүү хөтөлбөр нь хувь хүний хөгжилд суурилсан 6 сарын хөтөлбөр бөгөөд шалгарсан оюутнууд техникийн үр чадварыг хөгжүүлэх мастер хичээл, Англи хэлний сургалт, охидын манлайлал ба хувь хүний хөгжлийн уулзалт арга хэмжээнүүдэд хамрагдана. Түүнчлэн, МУИС-ийн мэргэжлийн багшийн удирдлаган дор ахлах ангийн охидод зориулсан зуны сургалтанд хичээл зааж, мэргэжлээ таниулах сайн дурын ажлын туршлага хуримтлуулах болно. Хөтөлбөрийн эцэст бүх арга хэмжээнд тасралтгүй оролцсон бөгөөд **тодорхой шалгуурыг хангасан оюутнуудад** зөөврийн компьютер олгоно.

Тавигдах Шаардлага

- 2022-2023 оны хичээлийн жилд МУИС-ийн 2-р түвшний суралцагч байх.
- STEM салбарын аль нэг чиглэлээр мэргэшиж буй суралцагч байх.
- Сурлагын голч дүн 3.0 буюу түүнээс дээш байх.
- Эцэг, эхийн аль нэг нь ганц бие өрх толгойлсон ба **байнгын тодорхой** орлоготой байх. (Хэрэв эцэг эхийн аль нэг нь хөдөлмөрийн чадвараа алдсан эсвэл хүнд өвчтэй бол хүндэтгэн үзэх шалтгаанд тооцно. Ийм тохиолдолд холбогдох нотолгоо бүрдүүлнэ.)
- Өөр ижил төстэй тэтгэлэгт хамрагдаагүй байх.
- Тэтгэлэгт хамрагдах хугацаандаа Монголд байх бөгөөд WE Mongolia ТББ-гаас зохион байгуулж буй бүх арга хэмжээнд биечлэн тогтмол, идэвхи санаачлагатай оролцох.



“STEM салбарт охидыг дэмжих”

Тэтгэлэгт Хөтөлбөр 2022-2023



- Өөрийн сонирхсон чиглэлээр хичээлээс гадуурх дугуйлан, эсвэл олимпиадад амжилттай оролцож, сайн дурын ажил хийж байсан туршлагатай байвал давуу тал болно.

Бүрдүүлэх Бичиг Баримтын Жагсаалт

1. Тэтгэлэгт хамрагдах өргөдлийн маягт
2. Ерөнхий Боловсролын гэрчилгээний хуулбар
3. Дүнгийн тодорхойлолт
4. Сургуулийн багш эсвэл менторын тодорхойлолт – 1 хувь
5. Ганцаараа авахуулсан зураг – 1 хувь (сонгон шалгаруулалтанд тэнцсэн тохиолдолд байгууллагын цахим хуудсаар мэдээлэхэд ашиглана)
6. Доорх сэдвээс аль нэгийг сонгон 1-3 хуудас эссэй бичих
 - Би яагаад _____ мэргэжлийг сонгосон бэ?
 - STEM тэтгэлэгт хамрагдсанаар ямар боломж нээгдэж байна? Түүнийг хэрхэн ашиглах вэ?
 - Ирээдүйн зорилгодоо хүрэхийн тулд өөрийгөө хэрхэн хөгжүүлдэг вэ?
 - Чөлөөт сэдэв

Нэмэлт материалууд:

7. Олимпиадад оролцож байсан бол, тодорхойлолт эсвэл гэрчилгээний хуулбар
8. Сайн дурын ажил хийж байсан бол, тодорхойлолт

Хүсэлт хүлээн авах эцсийн хугацаа:

2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл СиСи системээр бүртгүүлж, бүрдүүлэх бичиг баримтыг МУИС-ийн хичээлийн 2-р байрны 109 тоот өрөө, Оюутан, төгсөгчийн хэлтэст хүлээлгэн өгснөөр бүртгэл баталгаажна.

Мэдээлэл авах утас: 77307730-1514, 3400, n.altanzul@num.edu.mn

